

**Г.ТАМИР**

*Шүүхийн шийдвэр
гүйцэтгэлийн
сургуулийн нийгмийн
ажлын тэнхимийн
эрхлэгч, хурандаа*

ЭРЭН СУРВАЛЖЛАХ АЖИЛЛАГААНЫ ОНЦЛОГ

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь иргэний болон эрүүгийн хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх явцдаа хууль, тогтоомжийн хүрээнд олон талт үйл ажиллагаа явуулдаг. Эдгээр олон талд үйл ажиллагааны нэг чухал чиглэл буюу төрөл нь эрэн сурвалжлах ажиллагаа юм.

Тус байгууллагаас явуулдаг эрэн сурвалжлах ажиллагааны онцлог, төрөл хэлбэрийг судлахын өмнө эрэн сурвалжлах ажиллагаа гэж юуг ойлгох тухай хэл зүйн тайлбар болон хууль зүйн салбарын эрдэмтэн судлаачийн байр суурь, үзэл хандлагыг харьцуулан судалж, тодорхой ойлголттой болох учиртай. Эрэн сурвалжлах гэдэг нь эрэхээс үүсэлтэй хоршоо үйл үг юм.

Эрэх гэдэг нь 1-рт олс дээс зэрэг оосроор юмыг мушгин чангаруулах, юмыг эрэг, шургаар эрэгдэж шургадах, хадах, тогтоох 2-рт газар нүхлэн ухах, газар эрэх, эрж малтах, 3-рт эмэгтэйчүүдийн хөх булчирхайтаж өвдөх, хөх эрэх, эрхэх ч гэдэг, 4-рт мэдье, олъё гэж хайж сурвалжлах, эрэх сурах, эрэх хайх, эрэх сурвалжлах

Сурвалжлах гэдэг нь сураглах, мэдээ авчирах, нягтлах, сурвалжлан

эрэх, мэдээ сурвалжлах⁵⁹ гэсэн утгыг илэрхийлнэ.

Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 6-р зүйлд: "Эрэн сурвалжлах ажил" гэж Тагнуулын байгууллага цагдаа тахарын, хорих ял эдлүүлэх байгууллагад Эрүүгийн байцаан шийтгэх хууль болон бусад хууль тогтоомжоор харьяалуулсан эрүүгийн хэргийг илрүүлэх, түүнийг үйлдсэн этгээдийг олж тогтоох чиглэлээр хийх нууц ажиллагааг хэлнэ.⁶⁰ гэж тодорхойлсон.

Академич С.Нарангэрэл /Sc.D/ өөрийн бүтээлдээ: Эрэн сурвалжлах гэдэг нь мөрдөлт ба шүүхээс оргон зайлсан этгээдийг илрүүлэх, байгаа газрын тогтоох, ял эдлэхээс зайлсхийсэн шүүгдэгч буюу хорих газраас оргосон ялтныг олоход чиглэсэн төрийн эрх хэмжээ бүхий /хэрэг бүртгэх мөрдөн байцаах зэрэг/ байгууллагын үйл ажиллагаа юм. Хэрэв гэмт хэрэг үйлдсэн этгээд тодорхой бус түүнийг тогтоох арга хэмжээ эрэн сурвалжлах ойлголтонд хамаарахгүй бөгөөд гэмт хэргийг мөрдөх ба илрүүлэх агуулгатай болно⁶¹ гэсэн бол 3.Төрмандах өөрийн бүтээлдээ: Эрэн сурвалжлах ажил гэдэг нь оргон зайлсан гэмт хэрэгтэн, сураггүй алга болсон хүн ба бусад эрэн сурвалжлагдаж байгаа этгээдүүдийн орогнож нуугдах боломжийг илрүүлэн арилгахад чиглэсэн гүйцэтгэх ажлын тухай хууль болон түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн актуудын заалтад тулгуурлан эрх бүхий субъектүүдээс гүйцэтгэх тагнуулын ажлын мөрдөн

⁵⁹ Я.Цэвэл "Могол хэлний товч тайлбар тол" 1966, УБ

⁶⁰ <http://www.legalinfo.mn/law/details/229>

⁶¹ С.Нарангэрэл "Эрх зүйн эх толь бичиг" 2008, УБ, II дахь хэвлэл, 623 дахь тал

сурвалжлах хэргийн хүрээнд гүйцэтгэх тагнуулын ажлын, эрүүгийн байцаан шийтгэх, захиргааны эрх зүйн болон бусад арга хэмжээний нэгдсэн тогтолцоог хэлнэ⁶² гэж тус тус тодорхойлсон байна.

Орчин үед эрэн сурвалжлах ажиллагааны тухай эрдэмтэн судлаачдын байр суурь үндсэндээ 2 чиглэлд хуваагддаг. Нэг хэсэг нь эрэн сурвалжлах ажиллагааг тодорхой мэдэгдэж байгаа объектийг /оргож, нуугдсан сэжигтэн яллагдагч, ялтан, сураггүй алга болсон хүн, алдагдсан, гээгдсэн эд зүйл, мал, амьтан, гэх мэт/ олж тогтооход чиглэсэн үйл ажиллагаа гэсэн бол нөгөө хэсэг нь тодорхой биш объектыг /гэмт хэргийн ул мөр, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг тогтоох гэх мэт/ эрж хайх үйл ажиллагаа гэж үздэг.

Ихэнх эрдэмтэн судлаачид эрэн сурвалжлах ажиллагааг тодорхой болсон хүн, эд зүйл, мал амьтныг олж, тогтооход чиглэсэн үйл ажиллагаа гэсэнтэй санал нийлэх болсон бөгөөд тодорхой бус объектийг эрж хайх өөрөөр хэлбэл гэмт хэргийн ул мөр илрүүлэх, нотлох баримт цуглуулах, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг олж тогтоох үйл ажиллагаа нь эрэн сурвалжлах ажиллагаанд хамаарахгүй, харин гэмт хэргийг мөрдөх ба илрүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа юм гэж үзэх болжээ⁶³.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын эрэн сурвалжлах ажиллагаа нь агуулгын хувьд тээрхи тодорхойлолттой нийцдэг. Учир нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын эрэн сурвалжлах объект

ямагт тодорхой буюу хэнийг, юуг хайж олох нь тодорхой байдаг.

Нөгөө талаас эрдэмтэн, судлаачид уг ажиллагааг зөвхөн гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журмыг хамгаалах чиг үүрэгтэй эсхүл зөвхөн гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас явуулдаг тусгай ажиллагаа гэж явцуу хүрээнд тайлбарладаг.

Гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэггүй, гүйцэтгэх тагнуулын эрхгүй боловч зарим төрийн байгууллага эрэн сурвалжлах ажиллагаа явуулдаг. Тухайлбал: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 18-р зүйлд шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгчийг, Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөрлүүлэх тухай хуулийн 17 зүйлд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага эмнэлэгээс оргосон өвчтөнг эрэн сурвалжлах тухай хэм хэмжээг хуульчилсан байна.

Мөн цэргийн албанаас зайлсхийх зорилгоор оргон зайлсан хугацаат цэргийн албан хаагчийг эрэн сурвалжлах чиг үүргийг цэргийн анги, байгууллага гүйцэтгэдэг.

ТЕГ, ЦЕГ-ын даргын 2008 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 200/463 тоот тушаалын батлагдсан "Үндэсний татварын алба, Цагдаагийн байгууллагын хамтран ажиллах журам"-д татвар төлөхөөс зайлсхийсэн татвар төлөгчийн эрэн сурвалжлахад Цагдаагийн байгууллага, Татварын байгууллага хамтран ажиллах тухай заасан байна. Тэгэхээр эрэн сурвалжлах ажиллагаа нь төрийн байгууллага, албан тушаалтнаас хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхийн тулд явуулдаг нийтлэг

⁶² З.Төрмандах "Эрэн сурвалжлах ажил" 2010, УБ

⁶³ С.Нарангэрэл "Эрх зүйн эх толь бичиг" 2008, УБ, II дахь хэвлэл, 623 дахь тал

шинжтэй үйл ажиллагаа гэж үзэх үндэстэй байна.

Эрэн сурвалжлах ажил нь төрийн засаглах чиг үүргийг хэрэгжүүлж буй төрийн байгууллагуудын гүйцэтгэдэг нийтлэг шинжтэй үйл ажиллагаа гэж үзвэл энэ нь зөвхөн эрүүгийн байцаан шийтгэх, ял эдлүүлэх болон гүйцэтгэх тагнуулын ажиллагаагаар хязгаарлагдахгүй өргөн хүрээг хамарсан ойлголт ажээ.

Дээрхээс үзвэл эрэн сурвалжлах ажиллагааны талаар эрдэмтэн судлаачид нэгдсэн ойлголтонд хүрээгүй бөгөөд энэ нь онолын хувьд маргаантай асуудлуудын нэг болох нь тодорхой харагдаж байна. Иймд эрэн сурвалжлах ажиллагааны ойлголт, ялангуяа шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын эрэн сурвалжлах ажиллагааны онцлог, төрөл, хэлбэр, тактик арга зүйг судлах шаардлага зүйн ёсоор урган гарч байна.

Эрэн сурвалжлах ажиллагаа нь төрийн байгууллага, түүний дотор хууль сахиулах байгууллага, тусгай албадын олон талт үйл ажиллагааны бие даасан нэг чиглэл болдог бөгөөд үүгээрээ төрийн бус байгууллага, иргэдийн эрэл сурал, төстэй үйл ажиллагаанаас ялгагдаж байна. Жнь: хэн нэгэн иргэн алдагдсан гээгдсэн зүйл, хүн хүнээ эрж хайх явдал нь эрэн сурвалжлах ажиллагаа болохгүй. Үүнийг эрэл сурал гэж нэрлэж болох юм. Мөн эрэн сурвалжлах сэтгүүл зүйг адилтган ойлгож болохгүй. Эрэн сурвалжлах сэтгүүл зүй нь нийгэмд бугшсан шудрага бус явдал, нууц далд үйлдэгдэж буй гэмт явдлыг илчлэх, олон нийтэд мэдээлэх зорилготой байдаг.

Ухамсарт хүмүүний аливаа үйл ажиллагаа тодорхой зорилго, чиглэлтэй байдаг. Нөгөө талаас тухайн үйл ажиллагааг явуулж сүбъектийн үзэл хандлага /зарчим/ нь уг үйл ажиллааны явц, эцсийн үр дүнд нөлөөлдөг. Эрэн сурвалжлах ажиллагаа нь тодорхой зорилго чиглэлтэй бөгөөд уг үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд /явуулах/ сүбъектүүдийн зайлшгүй баримтлах шаардлагатай үзэл хандлага буюу зарчимтай. Уг ажиллагаа нь дараах зорилгыг агуулдаг байна. Үүнд:

А. Эрэн сурвалжлагдаж буй тодорхой объектийг олж илрүүлэх, байршлийг тогтоох

Б.Өөрийгөө илэрхийлж чадахгүй байгаа хүн болон хэн болох нь тогтоогдохгүй цогцос, эзэн нь тодорхойгүй мал, амьтан, эд зүйлд хамааралтай этгээдийг олж тогтоох

В.Урьдчилан сэргийлэх. Эрэн сурвалжлах ажиллагаа нь нийгэмд гэмт явдлаас урьдчилан сэргийлэх нөлөө үзүүлдэг өөрөөр хэлбэл уг ажиллагааны үр дүн өндөр байх тусам тодорхой үүрэг гүйцэтгэхээс зайлсхийж болзошгүй этгээд гэмт санаа бодлоосоо татгалзах, цаашлаад нийгэмд гэмт явдалаас урьдчилан сэргийлэх нөлөө үзүүлдэг байна.

Эрэн сурвалжлах ажиллагааг эрхлэн гүйцэтгэж буй сүбъектүүд уг үйл ажиллагаанд дараах зарчимуудыг зайлшгүй баримтлах шаардлагатай. Үүнд:

1. **Шуурхай байх.** Аливаа мэдээлэл, сэжиг таамаг, илрэлийг түргэн шуурхай шалгаж, шийдвэрлэх, арга хэмжээ авах явдлаар тайлбарлагдана.

2. **Тасралтгүй байх.** Эрэн сурвалжлах ажиллагаа мухардаж,

тодорхой сэжиг, таамаг байхгүй болсон ч эрэн сурвалжлах ажиллагааг үргэлжлүүлэх, эрэн сурвалжлах байгууллага, ажилтан уг ажиллагааг үр дүнд хүргэхийн тулд байнга хүчин чармайлт гаргах ёстой гэсэн агуулгыг илэрхийлнэ.

3. Нууцлалыг сахих. Гүйцэтгэх тагнуулын төдийгүй ердийн эрэн сурвалжлах ажиллагаанд ч нууцлал хамгаалах нь чухал ач холбогдолтой. Жнь: Чухал мэдээлэл өгсөн иргэнийг, эрэн сурвалжлах ажиллагааны явц үр дүн, арга тактик, хүн хүч, техник хэрэгслийг эрлийн объектоос нууцлах нь зайлшгүй.

4. Иргэд олон нийтийн туслалцаанд түшиглэх. Эрэн сурвалжлах ажиллагаанд олон нийт чухал үүрэгтэй.

5. Эрэн сурвалжлах субъектүүдийн хамтын үйл ажиллагааг чухалчилах. Эрэн сурвалжлах ажиллагаа нь төрийн байгууллагуудын хамтын үйл ажиллагаа, уялдаа холбоогүйгээр үр дүнд хүрэхгүй. Ялангуяа эрэн сурвалжлах чиг үүрэг бүхий байгууллагууд тодорхой объектийг эрэн сурвалжлахад /хэрэг/ хамтран ажилладаг. Ждлвл нь: Оргосон ялтныг эрэн сурвалжлах ажлыг дан ганц хорих байгууллагын хүчээр хийх боломжгүй. Цагдаа, Тахар, Хил хамгаалах, иргэний бүртгэл мэдээллийн зэрэг олон байгууллагын хамтын ажиллагаа, тусламж, дэмжлэг шаардагддаг. Мөн эрэн сурвалжлах ажиллагаанд чухал ач холбогдолтой мэдээллийг шуурхай солилцох, зарлан мэдээлэх ажил үүнд хамаарна.

Эрэн сурвалжлах ажиллагааг объект, субъект, ашиглаж буй арга хэрэгсэл, хамрах хүрээ, түүний

онцлогтой нь уялдуулан төрөлжүүлэн ангилж болох бөгөөд ингэх нь мэдлэгийг цэгцтэй бүтээхэд чухал ач холбогдолтой. Нөгөө талаас уг ажиллагаа нь өөрийн гэсэн өвөрмөц арга, зүй, тактикийн тусламжтайгаар хэрэгждэг ба практик хэрэгжилт нь тактик, арга зүйгээ улам баяжуулан хөгжүүлдэг зүй тогтолтой. Эрэн сурвалжлах ажиллагааг дараах байдлаар ангилж болох юм.

Нэг. Ашиглаж буй хүч, арга хэрэгслээр нь:

-Эрэн сурвалжлах нууц ажиллагаа. Энэ нь гүйцэтгэх тагнуулын ажлын нууц хүч, арга хэрэгсэл ашиглан нууц далд аргаар явуулж буй арга хэмжээ юм. Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 9-р зүйлд заасан эрх бүхий 7 байгууллага уг хуулиар харъяалуулсан асуудлын /зорилго/ хүрээнд нууц эрэн сурвалжлах ажиллагаа явуулдаг⁶⁴.

-Эрэн сурвалжлах ердийн ажиллагаа. Үүнд гүйцэтгэх тагнуулын ажлын нууц хүч арга, хэрэгслийг ашиглахгүйгээр гүйцэтгэж буй арга хэмжээнүүдийг ойлгоно. Гэвч ердийн эрэн сурвалжлах ажиллагаа нь объектоосоо нууцлагдах шаардлагатай болдог. Өөрөөр хэлбэл ердийн эрэн сурвалжлах ажиллагаа ч тодорхой хэмжээгээр нууцлалыг шаарддаг байна.

Мөн хуулиар гүйцэтгэх ажил явуулах эрх олгогдоогүй төрийн байгууллага, албан тушаалтан ердийн эрэн сурвалжлах ажиллагаа явуулдаг. Жнь: Төлбөр төлөгчийг эрэн сурвалжлах шийдвэр гүйцэтгэгчийн ажиллагааг ердийн эрэн сурвалжлах ажиллагаанд хамааруулж болно. Шийдвэр гүйцэтгэгчийн явуулдаг энэхүү

⁶⁴ <http://www.legalinfo.mn/law/details/229>

ердийн эрэн сурвалжлах ажиллагааг төлбөр төлөгчөөс нууцлах шаардлагатай. Түүнчлэн зарим эрэн сурвалжлах ажиллагаа нь өөрийн онцлог, объектоосгоо хамаарч нууцлал шаардахгүй байх тохиолдол ч байдаг. Жнь: Хэн болох нь тодорхойгүй цогцос, өөрийгөө илэрхийлж мэдэхгүй байгаа хүн, эзэн нь тодорхойгүй мал, амьтан, эд зүйл, өмч хөрөнгөд хамааралтай этгээдийг эрэн сурвалжлах, олж тогтоох, таниулах, иргэний бичиг баримтгүй хүнийг тодорхойлох гэх мэт ажиллагааг нууцлах шаардлага байхгүй.

Хоёр. Эрэн сурвалжлагдаж буй объектоор нь:

- Оргосон сэжигтэн, яллагдагч, ялтан, тодорхой үүрэг гүйцэтгэхээс зайлсхийсэн хүнийг эрэн сурвалжлах /Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүх, цагдан хорих байр, хорих ангиас оргон зайлсан этгээд, цэргийн оргодол, татвар, төлбөр төлөхөөс зайлсхийгчид, сэтгэл мэдрэлийн эмнэлэгээс оргосон өвчтөн, захиргааны журмаас саатуулагдсан этгээд, Монгол улсад оршин суух журам зөрчсөн гадаадын иргэн, харьяалалгүй, хүн гэх мэт/

- Сураггүй алга болсон, насбарсанд тооцогдсон хүнийг эрэн сурвалжлах

- Алдагдсан болон гээгдсэн эд зүйл, мал амьтан эрэн сурвалжлах / биет болон биет бус эд зүйл, бичиг баримт, үнэт эдлэл, өмч хөрөнгө, мал, тэжээвэр амьтан/

- Нуугдмал эд хөрөнгө илрүүлэх/ тодорхой үүрэг гүйцэтгэхээс зайлсхийх зорилгоор санаатайгаар өмч хөрөнгөө нуух тохиолдол гардаг/

- Хэн болох нь тодорхойгүй цогцос, өөрийгөө илэрхийлж мэдэхгүй байгаа хүн, эзэн нь тодорхойгүй мал, амьтан, эд зүйл, өмч хөрөнгөд хамааралтай

этгээдийг эрэн сурвалжлах, олж тогтоох

- Иргэний бичиг баримтгүй хүнийг тодорхойлох гэх мэт

Гурав. Эрэн сурвалжлах ажиллагаа явуулж буй субъектээр нь:

- Тагнуулын байгууллагын

- Цагдаагийн байгууллагын

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын

- Тахарын албаны

- Авилгалтай тэмцэх газрын

- Хил хамгаалах байгууллагын

- Бусад төрийн байгууллагын эрэн сурвалжлах ажиллагаа. /онцгой байдал, татвар, цэргийн анги нэгтгэл зэрэг төрийн бусад байгууллагууд хамаарна/

Дөрөв. Эрэн сурвалжлах ажиллагааны хүрээ, хэмжээ далайцаас нь хамаарч:

- Орон нутгийн хэмжээний

- Бүсчилсэн /бүс нутгийн хэмжээний/

- Улсын хэмжээний

- Олон улсын шинжтэй эрэн сурвалжлах ажиллагаа гэх мэтээр ангилж болно.

Иймд эрэн сурвалжлах ажиллагаа гэдэг нь тодорхой объект /хүн, эд зүйл, мал амьтан/-ыг эрж олох, баривчлах, байршилыг нь тогтоох зорилгоор хууль, тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу ердийн ба гүйцэтгэх тагнуулыг хүч арга, хэрэгсэл ашиглан төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас явуулж буй үйл ажиллагааг хэлнэ.

Уг ажиллагаа нь дараах шинжийг агуулдаг. Үүнд:

1. Зөвхөн төрийн байгууллага, албан тушаалтан хэрэгжүүлдэг.
2. Хууль, тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу хэрэгждэг.